



# МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 21 оны 05 дугаар  
сарын 25 -ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

## Тушаал шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.5 дахь заалт, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг нэгдүгээр, "Байгууллагын зүгээс /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хөл хорионы үед ажилтны бэлэн байдал, ар гэрийн аюулгүй байдлыг хангах зөвлөмж"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Түр журмын хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 47 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Шадар сайд



С.АМАРСАЙХАН

0021100234

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛЫН ҮЕД  
ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ  
ТҮР ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангах, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон Засгийн 2019 оны 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ыг тус тус удирдлага болгоно.

Хоёр.Түр журмын үйлчлэх хүрээ

- 2.1. Цар тахлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээг дараах хүүхдэд үзүүлнэ.
- 2.1.1 Коронавируст халдвар /Ковид-19/-ын шинжилгээгээр нотлогдсон хүүхэд;
  - 2.1.2 Тусгаарлан ажиглах байранд байгаа хүүхэд;
  - 2.1.3 Тэргүүн шугамд ажиллаж байгаа ажилтны хүүхэд;
  - 2.1.4 Хүчирхийлэлд өртсөн хүүхэд;
  - 2.1.5 Хөл хорионд орсон хүүхэд;
  - 2.1.6 Эцэг эх, асран хамгаалагч нь хөл хорионд орж, хараа хяналтгүй амьдарч байгаа хүүхэд;
  - 2.1.7 Эцэг эх, асран хамгаалагчгүй болсон /өнчирч үлдсэн/ хүүхэд;
  - 2.1.8 Тусгай асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд;
  - 2.1.9 Асрамж, халамжийн газар, дотуур байранд амьдарч байгаа хүүхэд;
  - 2.1.10 Цагдан хоригдож буй болон Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа хүүхэд;
  - 2.1.11 Отроор нүүдэллэн амьдарч байгаа малчдын хүүхэд;
  - 2.1.12 Бусад хүүхэд;

Гурав.Удирдлага, зохион байгуулалт, салбар дундын зохицуулалт

3.1. Цар тахлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлэх үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, эрүүл мэндийн, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь нутгийн захиргааны байгууллага, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, Хүний эрхийн үндэсний комисс, иргэний нийгмийн